



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 4/293

Номгон

Г Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамж, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хүүхэд, гэр бүлд зориулсан үйл ажиллагааг баганат талбайд зураглалын дагуу зохион байгуулж, албан байгууллагын дарга нар, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулахыг Баянхонгор сумын Засаг дарга (М.Насанбат)-д үүрэг болгосугай.

3.Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулалтаар ханган, удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайлан, мэдээллийг тусгай төрлийн баримт бүрдүүлэн 2026 оны 06 дугаар сарын 05-ны дотор аймгийн Засаг Даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

626010811

Аймгийн Засаг даргын 2026 оны 05 дугаар
сарын 12-ны өдрийн 17/293 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт

“ӨНӨӨДРИЙН БОЛОВСРОЛ-МАРГААШИЙН ХӨГЖИЛ”
УРИАН ДОР ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ууганцэцэг

Засаг даргын зөвлөх

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

В.Наранчимэг

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Д.Сарангарав

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

А.Өлзийсайхан

Аймгийн Засаг даргын тамгын газрын
Хүүхэд, гэр бүлийн асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Мөнхбаяр

Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн
Хурандаа

Лхагва-Очир

Эрүүл мэндийн газрын дарга

Л.Аюурзана

Боловсролын газрын дарга

Э.Бат-Өлзий

Байгаль орчны газрын дарга

Т.Эрдэнэбат

Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Пүрэвдагва

Соёл урлаг, аялал жуулчлал,
залуучуудын газрын дарга

Ц.Алтанцэцэг

Хөгжимт драмын театрын дарга

М.Насанбат

Баянхонгор сумын Засаг дарга

Ж.Батболд

Хүүхдийн Тэмүжин театрын дарга

Б.Түвшинчимэг

Нийтийн номын сангийн дарга

Д.Пүрэвсүрэн

Түүх угсаатны музейн дарга

С.Хүрэлсүх

Гон Гандан дэдлэн хийдийн лам
Зөвшилцсөнөөр

Нарийн бичгийн дарга:

Н.Мэндбаяр

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
газрын дарга

.....оОо.....

Аймгийн Засаг даргын 2026 оны 06 дугаар
сарын 01-ны өдрийн 1/2026 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг. Үндэслэл:

Женев хотноо 1924 онд “Хүүхдийн сайн сайхны төлөө” дэлхийн чуулга уулзалт зохион байгуулагдаж, 6 дугаар сарын 1-ний өдрийг дэлхий нийтээрээ “Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдөр” болгох уриалга гаргаж байсан. Монгол улс “Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуульд тус өдрийг оруулснаар 1952 оноос жил бүр тэмдэглэсээр энэ жил 74 дэх удаагаа зохион байгуулж байна.

Хоёр. Чиглэл:

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд “Өнөөдрийн боловсрол-Маргаашийн хөгжил” уриан дор эцэг эх, асран хамгаалагчдыг хүүхдэдээ болон гэр бүлдээ чанартай цаг гаргах уриалгыг дэвшүүлж, хүүхдийн эрхийг дээдэлж, хүүхдийн хөгжлийг дэмжин салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулан хамтран зохион байгуулна.

Гурав. Зорилго:

Хүүхдийн эрх, оролцоо, хөгжил, хамгааллыг дэмжих, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд бүрийн дуу хоолойг сонсох, аз жаргалтай дурсамж бүтээхэд оршино.

Дөрөв. Зохион байгуулах газар, хугацаа:

Баянхонгор сумын “Баганат талбай”-д 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдөр

Тав. Зохион байгуулагч:

- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл
- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- Боловсролын газар
- Цагдаагийн газар
- Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар
- Аймгийн хүүхдийн зөвлөл

Зургаа. Хамтран зохион байгуулагч

- Ерөнхий боловсролын сургуулиуд
- Цэцэрлэгүүд
- Политехник коллеж

Долоо. Ерөнхий зохион байгуулалт

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд “Өнөөдрийн боловсрол-Маргаашийн хөгжил” уриан дор төрийн байгууллагын төлөөлөл, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд хамтран хүүхдийн оюуны хөгжлийг дэмжих рубик шоо, шинжлэх ухаан инженерчлэл, Steam Hub, урлаг, спорт, хөгжөөнт тоглоом, зураг авхуулах хэсэг тохижуулах гэх мэт өөрсдийн санаачилгаар хүүхэд, гэр бүлийн оролцоог дэмжсэн үйл ажиллагааг хүртээмжтэй зохион байгуулна.

Найм. Үйл ажиллагааны хөтөлбөр

Нээлтийн үйл ажиллагаа				
1		2	3	4
Нээлтийн нэгдсэн арга хэмжээ /2026.06.01/				
Арга хэмжээ		Хугацаа	Хэрэгжилт	Хариуцах эзэн
1	Нээлтийн арга хэмжээ /Хөтлөгч нээж үг хэлнэ./	09:40-10:00	Хаврын баярын шилдэг оролцогчдын массын үзүүлбэр	Соёл урлаг аялал жуулчлал, залуучуудын газар , Хөгжимт драмын театр, Хүүхдийн тэмүжин театр
2	Орон нутгийн удирдлагууд мэндчилгээ дэвшүүлж үг хэлэх	10:00-10:20	АИТХ-ын дарга Б.Батсуурь Аймгийн Засаг дарга Э.Энхбат АЗДТГ-ын дарга П.Отгонбаяр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга В.Наранчимэг ХГБХХГ-ын дарга Н.Мэндбаяр Боловсролын газрын дарга Л.Аюурзана	Нийгмийн бодлогын хэлтэс
3	Плаш моб	10:20-10:30	300 хүүхдийн плаш моб бүжиг бэлтгэх	Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театр
4	Урлагийн тоглолт	10:30-11:30	Массыг хамарсан хүүхдүүдийн урлагийн тоглолт	Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театр
5	“Хонгорын хүүхэд” хөтөлбөрийн шагнал гардуулах арга хэмжээ	11:30-12:00	Хонгорын хүүхэд хөтөлбөрийн шилдгээр шалгарсан анги хамт олонд шагнал гардуулах	Нийгмийн бодлогын хэлтэс Хөтөлбөрийн ажлын хэсэг
6	Марафон гүйлт	12:00-13:00	Марафон гүйлтийн арга хэмжээг нээлттэйгээр зохион байгуулах	Марафон холбоо Биеийн тамир спортын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар
7	Open mic	13:00-14:00	Open mic арга хэмжээг нээлттэйгээр зохион байгуулах	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Аймгийн Хүүхдийн зөвлөл
Зохион байгуулагдах арга хэмжээ /2026.06.01/				
Баганат талбайд /Өртөөчилсөн хөтөлбөрт арга хэмжээ/				
8	Өртөөний дугаар	Өртөөний нэр	Арга хэмжээ	Хариуцах байгууллага
9	1-р өртөө	Шимт хөтөлбөр-1	Инженерчлэлийн технологийг таниулах арга хэмжээ	5-р цэцэрлэг 2-р цэцэрлэг
10	2-р өртөө	Шимт хөтөлбөр-2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	3,6-р цэцэрлэг
11	3-р өртөө	Шимт хөтөлбөр-3	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	7,8-р цэцэрлэг

1	2	3	4	5
12	4-р өртөө	Рубик шооны өртөө	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	9,10-р цэцэрлэг
13	5-р өртөө	Рубик шооны өртөө	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	11,12-р цэцэрлэг
14	6-р өртөө	Рубик шооны өртөө	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	13,14-р цэцэрлэг
15	7-р өртөө	IQ өртөө	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	15,16-р цэцэрлэг
16	8-р өртөө	IQ өртөө	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	1,4-р цэцэрлэг
17	9-р өртөө	“Дүдү машин” өртөө	“Дүдү машин” уралдаан зохион байгуулах	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар
18	10-р өртөө	“Steam hub”	“Steam hub” хөтөлбөрийг танилцуулах өртөө	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар
19	11-р өртөө	“Хамтдаа хөгжье” ХОӨУБ өртөө	Аймгийн Хүүхдийн зөвлөл, Мини парламент, Лидер сурагч академи, “Youth Power”, Улаан загалмай зэрэг хүүхдийн оролцооны байгууллагын гишүүдийн онцлогийг харуулсан тоглоомын өртөө	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар ХОӨУБ-ууд
20	12-р өртөө	“Бяцхан мисс, ханхүү”	“Бяцхан мисс, ханхүү” загварын уралдааныг бага насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах	Политехник коллеж
Оготнотой булагт зохион байгуулагдах спортын арга хэмжээ /2026.06.01-ны өдрийн 13:00-15:00 цагийн хооронд/				
21	Өсвөр насны сурагчдын дунд зохион байгуулах арга хэмжээ	Дугуйн уралдаан	Хүүхдийн насны онцлогт тохируулан аюулгүй байдлын ханган ажиллах	Эрдэм сургууль
22		“3х3” сагсан бөмбөгийн тэмцээн	Өсвөр насны сурагчдын дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулна.	Эрдэнэмандал сургууль
23		Скүүтрийн уралдаан	Хүүхдийн насны ангиллаар скүүтрийн уралдаан зохион байгуулах	Номгон сургууль
24		Волейболлын тэмцээн	8-9-р ангийн сурагчдын дунд	Соого сейкео сургууль
Динозавртай паркт зохион байгуулагдах арга хэмжээ /2026.06.01-ны өдрийн 13:00-15:00 цагийн хооронд/				
25	Хүүхэд гэр бүлийн дунд зохион байгуулагдах чөлөөт арга хэмжээ	“Гэр бүлийн хөгжилтэй буухиа”	Эцэг эх, хүүхэд хамтран саадтай зам туулах /олс таталт, бөмбөг дамжуулах/ зэрэг уралдаант буухиа тэмцээн зохион байгуулах	Номундалай, 5-р сургууль
26		Волейболын тэмцээн	10-12-р ангийн сурагчдын дунд	Гэгээн сумади
27		Волейболын тэмцээн	6-7-р ангийн сурагчдын дунд	Төгс-Алгоритм

Жич: Мазаалай паркт Хүнсний худалдааны үйлчилгээг зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

✓ Хүүхэд бүр аюулгүй орчинд хөгжих, тоглох, суралцах, санал бодлоо илэрхийлэх эрхтэй болохыг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид болон олон нийтэд таниулна.

✓ Урлаг, спорт, STEAM, инженерчлэл, рубик шоо, open mic, хөгжөөнт тоглоом зэрэг олон талт арга хэмжээнд хүүхдүүд өөрсдийн авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээгээ илэрхийлж, идэвхтэй оролцоно.

✓ Гэр бүлээрээ хамтран оролцох арга хэмжээ нь хүүхдэдээ чанартай цаг гаргах, тэдний хөгжлийг дэмжих, сэтгэл санааны холбоог бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

✓ “STEAM Hub”, “Шимт хөтөлбөр”, инженерчлэл, хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулснаар хүүхдийн авьяас, ур чадварыг хөгжүүлэх боломжуудыг таниулна.

✓ Хүүхэд бүрийн инээд хөөр, оролцоо, амжилтыг дэмжсэнээр өөртөө итгэх итгэл, нийгмийн идэвх оролцоо нэмэгдэнэ.

✓ Аймаг, орон нутгийн төрийн байгууллага, боловсролын байгууллага, хүүхдийн оролцооны байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хамтын ажиллагаа өргөжинө.

✓ “Хонгорын хүүхэд” хөтөлбөрийн шагнал гардуулах, урлаг, спортын арга хэмжээгээр дамжуулан хүүхдийн хичээл зүтгэл, амжилтыг олон нийтэд алдаршуулна.

✓ Марафон гүйлт, дугуйн уралдаан, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнээр дамжуулан хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрын хөгжил, эрүүл амьдралын дадлыг дэмжинэ.

Анхаарах асуудлууд:

1. Хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах

- Олны бөөгнөрөл, замын хөдөлгөөн, тоглоомын талбай, спортын тэмцээний үеийн аюулгүй байдлыг нарийвчлан зохион байгуулах.
- Эмнэлгийн анхан шатны тусламж, түргэн тусламжийн бэлэн байдлыг хангах.
- Хүүхэд төөрөх, гэмтэх, осолдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ ажиллуулах

- Түр хамгаалах болон зөвлөгөө өгөх цэг ажиллуулах.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх.

3. Хүртээмж, тэгш оролцоог хангах

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, алслагдсан багийн хүүхдүүдийг оролцуулах.
- Насны онцлогт тохирсон үйл ажиллагаа зохион байгуулах.

4. Эцэг эхийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх

- Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх талаар зөвлөмж хүргэх.
- Гэр бүлээрээ идэвхтэй оролцохыг уриалах.

5. Хүнсний аюулгүй байдал, худалдааны зохицуулалт

- Худалдаа, үйлчилгээний цэгүүдэд эрүүл ахуйн шаардлага мөрдүүлэх.

- Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн борлуулахгүй байх.
- 6. **Цаг агаарын нөхцөлд бэлтгэх**
 - Нарны хэт халалт, салхи, бороо зэрэг нөхцөлд тохирсон сүүдрэвч, ус, амрах талбай бэлтгэх.
- 7. **Хэв журам, цэвэрлэгээг хангах**
 - Хог хаягдлын сав, ариун цэврийн байгууламжийг хүрэлцээтэй байрлуулах.
 - Арга хэмжээний дараа орчны цэвэрлэгээг шуурхай зохион байгуулах.
- 8. **Мэдээлэл, сурталчилгааг үр дүнтэй хийх**
 - Хөтөлбөр, байршлын мэдээллийг тодорхой хүргэх.
 - Оролцогч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.

.....oOo.....